



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2022/80/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дархан-Уул аймаг 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр Утас: 7037-3089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 7037-3089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn Аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 9511-2689 Цахим хаяг: tsebs.audit@gmail.com</p>
----------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал.....	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	94
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11

Товчилсон үгийн жагсаалт


УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	255,887,591.31	258,186,949.32
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	29,272,264.33	42,442,609.66
311	Кассанд байгаа	-	
312	Банкинд байгаа	29,272,264.33	42,442,609.66
31210	Төгрөг	29,272,264.33	42,442,609.66
31211	Төрийн сангийн харилцах	29,272,264.33	42,442,609.66
33	АВЛАГА	224,018,835.98	213,147,848.66
334	Зээлийн хүүгийн авлага	8,107,265.31	5,623,321.98
333	Татаас, санхүүжилтийн авлага		
335	Бусад авлага	215,911,570.67	207,524,526.68
3351	Байгууллагаас авах авлага	417,150.00	400,000.00
3352	Хувь хүнээс авах	215,494,420.67	207,124,526.68
35	БАРАА МАТЕРИАЛ	2,596,491.00	2,596,491.00
354	Хангамжийн материал	2,596,491.00	2,596,491.00
35420	Аж ахуйн материал	2,596,491.00	2,596,491.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	450,000.00	300,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	450,000.00	300,000.00
393	Биет бус хөрөнгийн дүн	450,000.00	300,000.00
39301	Программ хангамж	750,000.00	750,000.00
39302	Хасагдуулга	(300,000.00)	(450,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	256,337,591.31	258,486,949.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	256,337,591.31	258,486,949.32
51	Засгийн газрын хувь оролцоо	256,337,591.31	258,486,949.32
511	Засгийн газрын оруулсан капитал	-	-
51101	Өмч: -төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	256,337,591.31	258,486,949.32
51210	Өмнөх үеийн үр дүн	254,097,944.32	256,337,591.31
51220	Тайлант үеийн үр дүн	2,239,646.99	2,149,358.01
51300	Дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	256,337,591.31	258,486,949.32



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,446,446.99	3,809,428.01
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,446,446.99	3,809,428.01
120	Нийтлэг татварын бус орлого	5,446,446.99	3,809,428.01
120002	Хүүгийн орлого		3,809,428.01
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,446,446.99	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	820,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,626,446.99	-
2	Үйл ажиллагааны зардал	3,206,800.00	1,660,070.00
21	Урсгал зардал	3,206,800.00	1,660,070.00
210	Бараа, үйлчилгээний зардал	3,206,800.00	1,660,070.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	144,170.00
210401	Бичиг хэргийн зардал		84,000.00
210404	Тээвэр шатахуун		60,170.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	3,056,800.00	1,365,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	3,056,800.00	1,365,900.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	150,000.00	150,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	150,000.00	150,000.00
213	Урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
3	Үйл ажиллагааны үр дүн	2,239,646.99	2,149,358.01
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	2,239,646.99	2,149,358.01



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	254,097,944.32	254,097,944.32
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			2,239,646.99	2,239,646.99
2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	256,337,591.31	256,337,591.31
2021 оны 01 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	256,337,591.31	256,337,591.31
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт		-		-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			2,149,358.01	2,149,358.01
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	258,486,949.32	258,486,949.32



2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/


Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	77,329,064.33	77,680,415.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	77,329,064.33	77,680,415.33
120	Нийтлэг татварын бус орлого	77,329,064.33	77,680,415.33
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	77,329,064.33	77,680,415.33
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,647,776.00	77,680,415.33
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	19,681,288.33	
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,056,800.00	1,510,070.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,056,800.00	1,510,070.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,056,800.00	1,510,070.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	3,056,800.00	1,510,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,056,800.00	1,510,070.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	74,272,264.33	76,170,345.33
4	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	-	-
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
23	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	45,000,000.00	63,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	45,000,000.00	63,000,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(63,000,000.00)
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	74,272,264.33	13,170,345.33
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		29,272,264.33
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,272,264.33	42,442,609.66



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	57,517,150.00	64,510,070.00	(6,992,920.00)	112.2
21	Урсгал зардлын дүн	2,517,150.00	1,510,070.00	1,007,080.00	60.0
210	Бараа үйлчилгээний зардал	2,517,150.00	1,510,070.00	1,007,080.00	60.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	2,517,150.00	1,510,070.00	1,007,080.00	60.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	2,517,150.00	1,510,070.00	1,007,080.00	60.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг			-	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			-	
	Дотоод эх үүсвэрээр			-	
	Тоног төхөөрөмж			-	
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	55,000,000.00	63,000,000.00	(8,000,000.00)	
	Эргэж төлөгдөх зээл	55,000,000.00	63,000,000.00	(8,000,000.00)	
	Бусад хөрөнгө			-	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	57,517,150.00	77,680,415.33	(20,163,265.33)	135.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	57,517,150.00	77,680,415.33	(20,163,265.33)	135.1
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,500,000.00	77,680,415.33	(20,180,415.33)	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	17,150.00	-	17,150.00	0.0
124	Бусад эх үүсвэр			-	
	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		29,272,264.33	(29,272,264.33)	
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		42,442,609.66	(42,442,609.66)	
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	
003	Төсвийн байгууллага			-	
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	-	-	-	
	Удирдах ажилтан			-	
	Гүйцэтгэх ажилтан			-	
	Үйлчлэх ажилтан			-	



Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын Сум хөгжүүлэх сангийн /цаашид Орхон сумын Сум хөгжүүлэх сан гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид гүйцэтгэж, хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, газрын дарга, тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/39 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон сумын Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.


3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,206.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 32.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 25.6 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,149.3 мянган төгрөгөөр буюу 0.8 хувиар өссөн өөрчлөлт нь авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	29,272.3	42,442.6	13,170.3
Авлага	224,018.8	213,147.8	(10,871.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	2,596.5	2,596.5	-
Үндсэн хөрөнгө	750.0	750.0	-
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	(300.0)	(450.0)	(150.0)
Нийт хөрөнгө	256,337.6	258,486.9	2,149.3
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо	256,337.6	258,486.9	2,149.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	256,337.6	258,486.9	2,149.3

Бараа материал дансны үлдэгдэл өөрчлөлт ороогүйн тайлант онд 144,2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, зарцуулан материалын үлдэгдэлд өөрчлөлт ороогүй байна.

Авлага дансны үлдэгдэл тайлант онд 10,871.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд нийт 63,314,2 мянган төгрөгийн зээлийг олгож, зээлийн хүү 3,809.4 мянган төгрөг нийт 67,123.6 мянган төгрөгөөр зээлийн авлага нэмэгдсэн байна. Мөн санхүүжилтийн авлага 17,2 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлж 2013 оноос хойш зээл авсан зээлийн хугацаа дууссан боловч зээлийн үлдэгдэлтэй байсан 23 иргэний 51,020.8 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг аймгийн ШШГА-аар албадан гүйцэтгүүлэх гэрээ байгуулан ажиллагаа хийж нийт 8,711.3 мянган төгрөгийг санд төвлөрүүлэн ажилласан нь зээлийн авлага буурах үзүүлэлт болсон, үндсэн зээлийн төлөлтийн хувиарийн дагуу төлөгдөж байгаа 65,456.7 мянган төгрөг, зээлийн хүүгийн 3,809.4 мянган төгрөг нийт 77,994.6 мянган төгрөгийг тус тус барагдуулсан байна.

Үндсэн хөрөнгийн дансанд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 258,486.9 мянган төгрөг болж 2,149.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,637.0 мянган төгрөгөөр буюу 69,9 хувиар буурахад төсөвт байгууллагын өөрийн орлогоор буурсан байна.

Урсгал зардал өмнөх оноос 1,546.7 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хангамж, бараа материалын зардал 144.2

мянган төгрөгөөр нэмэгдэж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 1,690.9 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнрүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 226,667.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 57,517.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 57,500.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, зээлийн хүү 17.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 77,680.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 64,510.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Орхон сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.


3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 148 мэдээллийг бүрэн оруулсан, 1 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.



3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 51,020.8 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийн биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 271 тоот албан бичгээр ирүүлсэн ба тайлагналын дараах үе шатанд дахин хянахад хэрэгжилт 17,1 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 42,309.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 42,309.4 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй байна.

4.2 Албан шаардлага.


4.2.1 Зээлийн хугацаа хэтэрсэн 42,309.4 мянган төгрөгийн зээлийн үлдэгдлийг шийдвэрлүүлээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Өр авлагыг цаг хугацаанд нь барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан-Уул аймгийн Орхон сумын Сум хөгжүүлэх сан	1	42,3	-	-	-	-	1	42,3	-	-
	Дүн	1	42,3	-	-	-	-	1	42,3	0	0

